



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны III байр
Утас: 7011-1284, Факс: (976-11) 31-15-09
<http://www.ub.inspection.gov.mn>
E-mail: ub_info@inspection.gov.mn

2017. 02. 22 № 02-01/628
танай _____ -ны № _____ -т

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд барилгын үйлдвэрлэлийн ажил эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр төлөвлөсөн.

Иймд Барилгын үйлдвэрлэлийн ажил эхэлж байгаатай холбогдуулан аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч нар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль болон холбогдох дүрэм журам, стандартыг хэрэгжүүлж аюулгүй ажиллахыг мэдэгдэж байна. Үүнд:

1. Монгол улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-д заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллага нь эрсдэлийн түвшингээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5%-иас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах.

2. Монгол улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.4-д заасны дагуу ажлын байранд учирч болзошгүй аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийх.

3. Нийслэлийн Иргэдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлын 75 дугаар тогтоолоор баталсан Барилга угсралтын үйл ажиллагаанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангах асуудлыг зохицуулах нийтлэг журмын 3.2.15- д Барилгын үйлдвэрлэлийн ажил эхлэхийн өмнө захиалагч, гүйцэтгэгч нар нь эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангах арга хэмжээний төлөвлөгөөг хамтран боловсруулж харъяа мэргэжлийн хяналтын байгууллагад ирүүлэх гэж заасны дагуу захиалагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь туслан гүйцэтгэгч байгууллагатайгаа хамтран тухайн барилгын гүйцэтгэх ажил үйлчилгээнээс хамааруулан эрсдэлийн үнэлгээг хийж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд зарцуулах хөрөнгийн хэмжээг тодорхойлж ажил гүйцэтгэх гэрээнд хэн нь

1150500932

13. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.6- д заасны дагуу гүйцэтгэгч байгууллагууд нь өөрийн барилгын үйлдвэрлэлийн онцлогт нийцсэн дүрэм журам, зааврыг заавал боловсруулж, тухайн гүйцэтгэж буй ажил үүрэгт нь тохирсон аюулгүй ажиллагааны зааварчилгыг тогтмол өгч хэвшүүлэх.

14. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-д заасны дагуу өргөх, зөөх тээвэрлэх хэрэгсэлд техникийн магадлагааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж зохих зөвшөөрлийг авч улсын бүртгэлд бүртгүүлсэн байна./МХЕГ, НМХГ-ын өргөх зөөх механизмын улсын байцаагчид хандах/

15. Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм БНБД 12-03-04-ийн 8.2.17-д заасны дагуу ачаа ачих буулгах үед дохиолол, оосорлох ажлыг, тухайн ажлыг гүйцэтгэх эрхийн үнэмлэх бүхий тусгай сургалтад хамрагдсан хүмүүсээр гүйцэтгүүлэх.

16. Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 2.3-д дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа бүрэн хамруулах.

Шалгалтаар хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй аж ахуйн нэгж, байгууллагыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4.10, НИХТХ-ын 75 дугаар тогтоолын 10.1-д заасны дагуу үйл ажиллагааг зогсоох, 10.2-д зөрчлөө арилгахгүйгээр ажлаа үргэлжлүүлсэн тохиолдолд барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг холбогдох газарт хүргүүлж хүчингүй болгуулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 36 дугаар зүйл, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу тус тус захиргааны хариуцлага ногдуулах болно.

НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН
ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Д.ЭРДЭНЭЧУЛУУН

хичнээн төгрөгний хөрөнгийг гаргаж, хэн нь хаалт хамгаалалтаа хийхийг заавал тусгасан байх.

4. Дээрхи журмын 2.1.1-д заасны дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талбайн зохион байгуулалтын зурагт барилгын үйлдвэрлэлийн талбайн зам гарц, ажиллагсдын түр байр, хоолны болон бие засах газар, материал хураах талбайн байршил, машин механизм байрлуулах болон тэдгээрийн орох гарах гарц, аюултай бүсийг тодорхойлсон тэмдэг тэмдэглэгээг харуулсан байх бөгөөд уг схем зургийг 2*3 метрийн хэмжээтэй бүгдэд харагдахуйц байхаар ил байрлуулах.

5. Журмын 2.1.2-т заасны дагуу барилгын талбайн орох хаалганы орчимд баригдах барилгын тухай мэдээлэл, захиалагч, ерөнхий гүйцэтгэгч компаний нэр, хаяг холбоо барих утас, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны нэр, холбоо барих утсыг бичиж нийтэд харагдахуйцаар байрлуулах.

6. Журмын 2.1.3-д заасны дагуу барилгын ойролцоох гаднах орчинд зорчих, олон нийтийн аюулгүй байдлыг хангасан, тэдний нэвтрэх боломжийг хязгаарласан 3 метрээс багагүй хотын өнгө үзэмжинд нийцсэн хашаагаар хамгаалах.

7. Журмын 2.1.4-д заасны дагуу үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйлүүд байнга үйлчилж болох болон үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйлүүд тохиолдож болзошгүй бүсийг урьдчилан сэргийлэх, дохио санамж, анхааруулга, аюулгүйн тэмдэг бүхий хаалт хамгаалалтаар тусгаарлах.

8. Журмын 3.2.2-д заасны дагуу барилга угсралтын явцад барилгын гадна шат, ванданг уртын дагууд 4 метрээс багагүй, шатны босоо чиглэлд 2 үе тутамд барилгын үндсэн хийцэд бэхлэх, бариул шат, орц гарц гаргах, бат бэх тороор битүүлэх.

9. Журмын 3.2.3-д заасны дагуу барилгын өндрийн дагууд 2-3 давхар тутамд уналтаас хамгаалах 3,5 метрээс багагүй өргөнтэй хамгаалалтын тороор тоноглох. /хамгаалалтын торны даацыг 80-100 кг ачааг даахаар тооцох/

10. Журмын 3.2.4-д заасны дагуу салхивч, шугам хоолой, шат, лифтний хонгил болон барилгын гаднах өндрөөс унаж болзошгүй бүсийн хаалт, хамгаалалт, нийтийн эзэмшлийн зам талбайн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллах

11. Журмын 9.1.2-д заасны дагуу захиалагч болон ерөнхий гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэгч байгууллагаар барилгын үйлдвэрлэлийн ажил гүйцэтгүүлэхдээ тусгай зөвшөөрөлгүй аж ахуйн нэгж, байгууллага болон иргэнээр ажил гүйцэтгүүлэхгүй байх.

12. Журмын 8-д заасан барилгын үйлдвэрлэлийн талбайд байх бичиг баримтуудыг мэргэжлийн хяналтын улсын байцаагчдыг хяналт шалгалтаар очход бэлэн байлгах